

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАЙ ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2011.03.01.

Чойр хот

№	Батламжийн агуулга	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
1	Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана;	Аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахдаа аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж өөрийн 2008-2012 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгуулахаар иргэдээс гаргасан саналыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн мөрийн хөтөлбөртөө тусган батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцтай салшгүй холбоотой бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн аймагт хамааралтай 153 заалтыг хяналтанд авч салбрын бодлого хариуцсан хэлтэс, агентлаг, газруудад хариуцуулан эзэнжүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байгаа ба 2010 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 64,2 хувийн биелэлттэй байна.	100
2	Төр, засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллана;	Төр засгийн төлөөлөгчийн хувьд албан үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн хууль ёсыг чандлан сахиж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх үүргийг мөрдөн ажиллаж байна.	100
3	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ;	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид, ил тод, нээлттэй байлгах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд: Говьсүмбэрийн мэдээ сонин, FM ярилцлага, иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөг, айл өрхөөр явж тэдний амьдрал ахуйтай танилцаж төрийн үйлчилгээг хүргэх, малчдаар явж үйлчлэх, нэг цэгийн үйлчилгээ зэрэг олон хэлбэрээр хүргэж байна. Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөгийг энэ онд Баянтал, Шивээговь сумдад тус бүр 2 удаа, Сүмбэр суманд 3 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс албад болон иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд давхардсан тоогоор 14140 иргэнд үйлчилгээ үзүүлж, 10098 гарын авлага, тараах материал, ном, сонин тарааж, 377 иргэнээс санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч, 373 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэж, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос хүртэх боломжийг бүрдүүлж ажиллалаа. Нэг цонхны үйлчилгээ нээгдсэн цагаас хойш үйл ажиллагаа нь тогтмолжиж төрөөс үзүүлж буй үйлчилгээг нэг дороос олон төрлийн хэлбэрээр үзүүлж ирлээ. Нэг цонхны үйлчилгээ нь иргэдэд хөдөлмөр халамж, нийгмийн даатгал, худалдаа үйлчилгээ, газрын харилцаа, иргэний бүртгэл, мэдээлэл, мэдээлэл, лавлагаа, зөвлөмж өгөх, нотариат, банк гэсэн үйлчилгээг үзүүлснээр иргэд төрийн үйлчилгээг нэг дороос авч сард дунджаар 2699 иргэн, нийт 32387 иргэн үйлчлүүлсэн байна. “ Говьсүмбэр нутгаа хөгжүүлье ” FM ярилцлагыг 21	100

		<p>удаа зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын 4 хэлтэс, 11 агентлаг оролцож өөрсдийн ажил үйлчилгээгээ сурталчилж, цаг үеийн мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж 126 иргэний сонирхсон асуултанд хариулт өглөө.</p> <p>Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан “Малчдад туслах аян” зохион байгуулж хандивын дансанд 12, 336,0 мянган төгрөг төвлөрснөөр малчдад туслах санг бүрдүүлээд байна. Аймгийн Засаг дарга нөөцөөсөө хөрөнгө гаргаж хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилт, малчдын амьдрал ахуйтай танилцах зорилгоор аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар аймгийн Засаг даргын зөвлөлийн зарим гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд 2 удаа явж давхардсан тоогоор 258 өрхөөр орж хүн, мал эмнэлгийн болон төрийн бусад үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Хөдөөгийн малчин өрхүүдэд 4925 кг гурил, 250 кг будаа, 160 толгой лаа, 2240 ширхэг шүдэнз, 75 кг сармис бэлэн хоол 1000, бээлий 116, элгэвч 232, нэмнээ 36, нүдний шил 85, тусламжийн хувцас, сонин сэтгүүл 190,0 тн нүүрс хуваарилж хүргүүлэв.</p> <p>Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас явуулж буй үйл ажиллагаагаа иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэх, шийдсэн асуудлаа иргэддээ таниулж аливаа асуудлыг тэдний идэвхитэй оролцоо, хяналтан доор хэрэгжүүлж байх боломжийг бүрдүүлэх зорилт тавин уулзалт цуглаан зохион байгуулах, орон нутгийн сонин , телевиз, FM ярилцлага хийх , аймгийн вэб хуудсанд мэдээллийг тавих, санал асуулга авах, саналын хайрцгаар санал хүсэлтийг авах зэргээр иргэдэд мэдээллийг хүргэж мөн дээрх хэлбэрээр иргэдийн санал хүсэлтийг авч шийдвэрлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Иргэдтэй хийх уулзалтыг хэсэгчилсэн хэлбэрээр тодорхой зорилтот бүлгүүдийн хэмжээнд зохион байгуулж байгаа бөгөөд энэ онд Такси үйлчилгээ, бизнес эрхлэгчид, залуучууд, ахмадын төлөөлөл, Төрийн бус байгууллагын төлөөллийг аймгийн удирдлагууд хүлээн авч бодлого чиглэлээ таниулж тэдний тавьсан хүсэлтийг шийдвэрлэж өглөө.</p> <p>2009 оны үйл ажиллагааны үр дүн, 2010 оны бодлого чиглэлээ иргэдэдээ таниулах уулзалтыг сумдад зохион байгуулж нийт 484 иргэн оролцлоо.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагтай хамтарч Сүмбэр сумын 906 өрх, Шивээговь сумын гэр хороолол, орон сууцны байрны 154 өрх, Баянтал сумын 12 өрхөөр орж, нийт 3591 иргэдтэй уулзаж Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, орон нутгийн цаг үеийн ажлын мэдээ мэдээллийг танилцуулж 807 иргэнээс аймаг, сум, баг болон бусад төрийн үйлчилгээний байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх санал асуулгыг авч дүгнэлт хийж ажиллалаа.</p> <p>Энэ үеэр иргэдээс 128 санал хүсэлт гарсныг холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлж шийдвэрлүүллээ.</p> <p>Дээрх ажлын үр дүнд аймгийн Засаг даргаас нэн түрүүнд тусламж дэмжлэг шаардлагатай байгаа 73 өрхөд нэг ээлжийн шинэ хувцас, хүнсний тусалцаа үзүүлж, гэр оронгүй гэсэн 14 өрхөд судалгаа хийж 3 өрхөд гэр олголоо.</p>	
4	Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авлига, хээл хахуулийг цээрлэн ажиллана.	Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласны үр дүнд татварын орлогын төлөвлөгөө 2010 оны эхэнд 1450,1 сая төгрөгөөр батлагдаж, оны эцэст орон нутгийн орлогыг 2023,8 сая төгрөг, урьд оны давсан орлого 256., сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 217,6 сая төгрөгийн эх үүсвэртэй болж, тайлант хугацаанд орон нутгийн төсвийн орлогыг 1098,8 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Дээрхи хөрөнгөнөөс	

		<p>орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхэд 985,6 сая төгрөгийг зарцуулж, урсгал зардлыг багасгах зарчмыг баримтлан ажилласан. Орон нутгийн орлого 2271,4 сая төгрөг буюу 112,2 хувиар биелсэн.</p> <p>Төсвийн сахилгыг чанд сахиулахад анхааран ажиллаж оны эхнээс төсөвт байгууллагуудын Ерөнхий менежер, нягтлан бодогч нартай тайлан мэдээ тушаалт, төсвийн хэтрэлтгүй ажиллах, өр авлага, бууруулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласны үр дүнд улсын төсвийн байгууллагын авлага 9.8 сая төгрөг буюу оны эхний үлдэгдлээс 9.2 сая төгрөгөөр буурсан. Харин өглөг 53.7 сая төгрөгөөр өссөн байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан өр авлага шинээр үүсээгүй. Нийт өглөгийн 82.6 хувийг Эрүүл мэндийн сайдын эмийн зардлын тооцоо, 16,2 хувийг нь Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын түлш халаалтын тооцоо эзэлж байгаа ба төсвийн төлөвлөлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн өглөг болно.</p> <p>2010 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийг 288,0 сая төгрөгөөр хэмнэсэн дүн гарсан. Үүнээс 220,2 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын он дамжсан 2 ажил эзэлж байна. Санхүүгийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг өндөржүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын мэдлэгийн түвшинг тогтоон нягтлан бодогч нарыг байгууллага хооронд сэлгэн ажиллуулах арга хэмжээ авсан.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан авилга хээл хахуультай холбоотой хэрэг зөрчлийн шалтгаан нөцлийг судлах, түүнийг арилгах арга хэмжээ авч ажиллах талаар Цагдаагийн хэлтэст үүрэг өгөн ажиллаж байна.</p> <p>Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд нь гаргуулах, бүртгэх, хадгалах, тайлагнах асуудлыг ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн даргад хариуцуулан ажиллаж байна.</p>	100
5	<p>Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ, соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хөгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана.</p>	<p>Аймгийн хөгжлийн бодлогын тулгуур болсон нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах зорилгоор “Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай байх” нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 44 үйл ажиллагааг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ирлээ. 2010 онд Соёл боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх иргэдэд үйлчлэх тав тухтай орчинг бүрдүүлэх үйлчилгээний стандарт, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, чиглэлээр доорхи ажлуудыг хийлээ.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагын хувьд: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, иргэд, хамт олны идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амыг эрүүл байлгах, орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний аргыг эрчимтэй нэвтрүүлэн эрүүлжүүлэх замаар дундаж наслалтыг уртасгах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах чиглэл дээр анхааран ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих хүн амын 97 хувь нь хамрагдаж, аймгийн төвийн хүн амын 98 хувь нь өрхийн эмнэлэгт харъяалагдан үйлчлүүлж байна. Эх нялхсын эрүүл мэндэд анхааран “Мянганы хөгжлийн тунхаглал”-д нийцүүлэн нялхсын эндэгдэл, эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөөний дагуу жирэмсэний хяналтыг эрт тогтоох, жирэмслэлтэй холбоотой эмгэгийн оношлогоог сайжруулах бодлого барьж 2005 - 2010 онд эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлжээ. Эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн дөрвөн жилд</p>	100

эхийн эндэгдэл гараагүй.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 7 тохиолдлоор буурч 1 тохиолдол бүртгэгдсэн. 2009 онд нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөнд 22.2 байсан бол тухайн жилд 2.7 болж буурсан нь улсын /19.4/ болон аймгийн /22.1/ дунджаас бага байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 5.3 байгаа нь улс /24.6/ аймгийн /28.0/дунджаас бага байна.

Бүртгэгдсэн бүх халдварт өвчин өмнөх оноос 130 тохиолдлоор нэмэгдэж 279 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд ноогдох халдварт өвчин 209.9 байгаа нь улс / 151.2/ болон аймгийн / 122.9/ дунджаас өндөр байна.

0-5 насны хүүхдийн дархлаажуулалт 99.8 хувьд хүрсэний үр дүнд тарилгатай халдварт өвчин гараагүй. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсгэн байгуулах санаачлагыг дэмжин ажилласанаар одоогийн байдлаар шүдний эмнэлэг 1, эмийн худалдаа 7, Уламжлалт эмчилгээний чиглэлээр 1 эмнэлэг ажиллаж байна.

Нэгдсэн эмнэлгийн стандарт 85 хувь, сумдын эмнэлгийн стандарт 90 хувь, өрхийн эмнэлгийн стандарт 85 хувийн хэрэгжилттэй байна. Эмнэлэг эмийн сангийн хооронд үүссэн өр авлага байхгүй.

Сумын эмнэлгүүд их эмчээр бүрэн хангагдсан. Эрүүл мэндийн яамны 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэгт их засвар хийж үйлчлүүлэгчдийн тав тухтай орчныг бүрдүүллээ.

2010 онд эрүүл мэндийн байгууллагуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 65 сая төгрөг , орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5990.0 мянган төгрөг, хөтөлбөр төслийн хүрээнд 73 сая төгрөг, нийт 2 тэрбум 24 сая 800.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 19 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашинаар хангагдаад байна.

Эмч нарын мэргэжил мэргэшлийг үе шаттайгаар дээшлүүлж гадаад, дотоодын сургалтанд хамруулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ядуурлыг бууруулж, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр болон улсын төсөв, хувь хүний хөрөнгө оруулалтаар 300 ажлын байр шинээр бий болсны 252 нь байнгын ажлын байр байна. Аймгийн хэмжээнд 70 өрхийг сонгон өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэн ажилласан ба мөн иргэдийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлж ажиллалаа. Энэ талаар Мерси кор, Дэлхийн зөн, АЙФО зэрэг олон улсын байгууллагуудаас гадна Ариун-Учрал орон нутгийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан. Эдгээр арга хэмжээний үр дүнд 2010 оны жилийн эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 2.8 хувьтай байна.

Соёл, боловсролын байгууллагын хүрээнд:

2010-2011 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 4 сургуулийн 101 бүлэгт 2908 хүүхэд, 7 цэцэрлэгийн 40 бүлэгт 1167 хүүхэд суралцаж нийт 199 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 91.2 хувь, бага боловсролын хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 99.1 хувьтай байна. Баянтал сумын цэцэрлэг сургуулийн дотуур байрыг шинэ байртай болгосон ба аймгийн хэмжээнд дотуур байранд хамрагдвал зохих хүүхдүүдийг 100 хамруулж байна. Улсын төсвийн 374,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд 640 хүүхдийн

		<p>сургуулийн барилгын ажлыг эхлүүлсэн ба барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн барилга, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл хийгдэж ашиглалтанд орж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Дээрх цэцэрлэгийн барилгууд ашиглалтад орсноор сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт нэмэгдэж 91.2 хувьд хүрсэн ба өмнөх жилийнхтэй харьцуулахад 3.8 хувиар өссөн.</p> <p>2009-2010 оны хичээлийн жилд 9-11 дүгээр ангийг 636 хүүхэд төгссөнөөс суурь боловсролыг 354 хүүхэд, бүрэн дунд боловсролыг 282 хүүхэд эзэмшлээ. Аймгийн хэмжээнд сургалтын стандарт хангалтын түвшин 85 хувьд хүрч өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар ахисан үзүүлэлттэй байна.</p> <p>Мэргэжлийн урлагийн байгууллага болох Боржигин чуулга нь шинэлэг оновчтой менежменттэй ажилласанаар чуулгын уран бүтээлчдийн орон тоог 57-д хүргэж мэргэжлийн уран бүтээлчдийн хангалт 92 хувьтай байна. Шинээр болон сэргээн тавьж байгаа уран бүтээлүүдийг мэргэжлийн урлагийн байгууллагын хэмжээнд хүргэн тогтмол баяжилт хийн ажиллаж байна.</p> <p>Номын сангийн үйлчилгээнд автоматжуулалт, мэдээлэл технологийн үйлчилгээг нэвтрүүлэн электрон каталогийг үүсгэн электрон хайлтын компьютерт суурилуулж интернет мэдээллийн үйлчилгээг тогтмолжуулж уншлага үйлчилгээг зөвхөн танхимаар явуулаад зогсохгүй төрөлжүүлэн явуулахад анхаарч ажиллалаа. Энэ онд орон нутгийн хөрөгө оруулалтаар аймгийн музей номын сангийн барилын ажлыг эхлүүлсэн бөгөөд барилгын гүйцэтгэл 50 хувьтай байна.</p>	
6	<p>Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж ажиллана;</p>	<p>Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй хэвийн хэмжээнд байлгах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгууллаа. Цагдаагийн хэлтсийн ажил, үйлчилгээгээ сайжруулах талаар тавьсан саналыг шийдвэрлүүлэх зорилгоор 7 хоног, сар бүр аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд 26 удаа үнэлэлт дүгнэлт хийж ажиллалаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тавьсан 3 саналын хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвөлгөөн”, архины хамааралтай иргэдийн сургуулийн насны 10 хүүхдэд бэлэг гардуулах, “Замын хөдөлгөөний соёл-2010” зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Аймаг орон нутгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн холбогдогчийн талаар орон нутгийн Боржигин FM-102.5 радиогоор сар бүрийн эхний 7 хоногт Мэдээлэл хийж хэвшээд байна. Аймгийн Засаг даргын ивээл дор “Архидалтын эсрэг хамтдаа” зөвлөгөөнийг хууль хяналтын байгууллага, Архидалт мансуурлын эсрэг ассоциаци, аймгийн Төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулж, архинд хамааралтай иргэд, архи худалдан борлуулдаг цэг салбарын ажилтнууд зэрэг 100 гаруй хүн хамрагдаж, 500 мянган төгрөг зарцуулсан. Аймгийн Наркологийн танхимыг 4,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан архи байнга хэрэглэдэг 55 хүнтэй наркологич нийгмийн ажилтны хамт биечлэн уулзаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч амьдрал ахуй орчин, архи хэтрүүлэн хэрэглэж буй шалтгаан нөхцлийг нь судлан хорт зуршлаас нь ангижруулах талаар хамтран тэмцэх ажлыг эхлүүлээд байна. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, байгууллага одоогоор байхгүй. Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй</p>	100

		<p>21 аж ахуйн нэгжийн 25 цэгийн үйл ажиллагаанд "... стандартын хэрэгжилт, татвар төлөлтийн байдал, ажиллагсдаа нийгмийн даатгалд хамруулж байгаа байдал, хөдөлмөрийн хуулийн хэрэгжилт, цалин тогтоолт, олголт, бусад" гэсэн үзүүлэлттэй удирдамжийн дагуу атестатчлал явуулж 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, ололттой талыг сурталчилж, дутагдалтай байгууллагуудад 9 зүйл бүхий зөвлөмж хүргүүлэн үн дүнг тооцон ажиллаж байна.. Архидан согтуурахад гол нөлөө үзүүлдэг Хямд үнэтэй стандартын бус архийг хууль бусаар зарж борлуулж буй байдлыг илрүүлэх талаар "Хуурамч акц" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулсан.</p> <p>Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор архины хамааралтай гэр бүлд өсөж байгаа өрхийн хүүхдүүдийг сонгож авч, Цагдаагийн хэлтсийн хүүхдийн алба, аймгийн ГХУСАЗЗ, Эрүүл мэндийн газар, "Ариун-Учрал" төрийн бус байгууллагатай хамтран "Гэрэлт ирээдүй" төслийг Мерси Кор ОУ-ын байгууллага, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж, төсөлд хүнд нөхцөлд амьдарч байгаа болон тодорхой хэмжээгээр эрх нь зөрчигдөж байгаа нэн ядуу өрхийн 30 хүүхэд хамрагдлаа. Энэ онд аймгийн хэмжээнд 119 гэмт хэрэг гарсан нь өмнөх онтой харьцуулахад 46-аар буюу 27,,9 хувиар буурлаа.</p> <p>Архитай холбоотой асуудлыг ноцтой зөрчилд тооцож байх талаар тодорхой үүрэг чиглэл өгч байгууллагуудын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгаж өгсөн. Сахилга хариуцлагыг чангатгаж Ерөнхий менежерүүдтэй байгуулсан гэрээнд заалт тусган мөрдөж, зөрчил гаргасан аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагч, 2 сумын Засаг даргыг ажлаас нь чөлөөлж, зөрчил гаргасан аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчид сахилгын шийтгэл, ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах үедээ архи согтууруулах ундаа хэрэглэсэн Баянтал сумын ЗДТГазрын 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл тус тус ноогдуулсан.</p>	
7	Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцаа авч ажиллана;	<p>Монгол улсын Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж /улирал, хагас жил, жилээр/ шаардлагатай дэмжлэг туслалцааг авч ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол, шийдвэрээс аймагт хамааралтай орон нутагт хэрэгжүүлбэл зохих 114 шийдвэрийн 170 заалтыг хяналтанд авч холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдэд хариуцуулан хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавин ажиллалаа.</p> <p>Эдгээр тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэвшсэн бөгөөд энэ оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт 92,1 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 95,1 хувийн хэрэгжилттэй байна.</p>	90
8	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгоор ашигласан авлига, хээл хахуульд холбогдсон ёс суртахууны	<p>Аймгийн Засаг дарга миний бие хуулиар хүлээсэн эрх үүргээ ухамсарлан албан үүргээ гүйцэтгэхдээ төрийн хууль ёсыг чандлан сахиж мөрдөн ажиллаж байна. Төсвийн хөрөнгийг хууль, журмын дагуу зүй зохистой зарцуулахад анхааран ажиллаж ирлээ. Ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэх, үйл ажиллагаанд нь үнэлгээ өгөх, урамшуулал олгох хариуцлага тооцох журмын дагуу Ерөнхий менежерүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээ мөн Сумдын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний явц байдалд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж</p>	100

	доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаасаа чөлөөлөгдөх асуудал нь улс төрийн намын хаацайллыг эрэлхийлэх шалтгаан болохгүй.	дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээнүүдийг авч байна. Ерөнхий менежерүүдийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа өөрийн болон хамт олны ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг онцгой анхаарч үздэг.	
9	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил тутам Засгийн газарт тайлагнана;	Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжаар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийн, Монгол Улсын Засгийн газарт хагас, бүтэн жилээр тайлагнаж хэвшсэн. 2010 оны жилийн эцсийн байдлаар батламж 98,9 хувийн хэрэгжилттэй байна.	100

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Арга хэмжээний тоо	Үүнээс							Хугацаа болоогүй	Тасарсан		БИЕЛЭЛТИЙН ДҮН / хувь /
		Биелсэн /100/	Хэрэгжих шатандаа / % /					0		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас	
			90%	70%	50%	30%	10%					
Бүгд	9	8	1	-	-	-	-	-	-	-	98,9	

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ж.БАЯНМӨНХ